



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 11 өдөр

Дугаар А/55

Есөнбулаг

Эрх шилжүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн Худалдаан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай 02 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 71 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн төсвийн 19,000,000 (арван есөн сая) төгрөгийн эх үүсвэрээр Засгийн газрын Хөдөөгийн сэргэлт бодлогын хүрээнд цахим хөдөө аж ахуй платформ программ нэвтрүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу худалдан авах ажиллагаа зохион байгуулан, хэрэгжүүлэх эрхийг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Т.Сүхбаатар)-д шилжүүлсүгэй.

2. Ажил гүйцэтгэх хугацаа, ажлын даалгавар, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Т.Сүхбаатар)-д үүрэг болгосугай.

3. Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ

C:\Documents\ ZDA4

8235010200

